

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД БҮРТГЭЛ ХЯНАЛТАД АВСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023 оны 11 дүгээр сарын 06

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын батлан гаргасан захирамжийн 2023 оны 3 дугаар улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар хийлээ.



Аймгийн Засаг даргын батлан гаргасан захирамжаас 2023 оны 2 дугаар улиралд 30 захирамжийн 33 заалтыг хяналтад авч, Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2023 оны 10 сарын 25-ны өдөр эцсийн байдлаар ирүүлсэн.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар улиралд хяналтад авсан 30 захирамжийн 33 заалт 84.8 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь -20, 90 хувь-2, 70 хувь -7, 50 хувь-2, 30 хувь -1, 0 хувь -1 заалт байна.

2 дугаар улирлын хэрэгжилттэй харьцуулахад 6.5 хувиар буурсан байна.

Хэрэгжилтийн хувь болон эзлэх хувийг графикаар харуулбал:



Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 20 заалт нь нийт заалтын 60.6 хувийг, хэрэгжих шатандаа буюу 90 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт нь 6 хувийг, 70 хувьтай хэрэгжиж байгаа 7 заалт нь 21.2 хувийг, 50 хувьтай хэрэгжиж байгаа 2

заалт нь 6 хувийг, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 1 заалт нь 3 хувийг, 0 хувьтай 1 заалт нь 3 хувийг тус тус эзэлсэн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан захирамжийг 2023 оны 3 дугаар улиралд 84.8 хувьтай хэрэгжиж байна. Энэ улиралд хэрэгжилт тооцсон захирамжуудаас дараах заалтууд хэрэгжилт удаашралтай байгаа болон эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр дүгнэж, зөвлөлд танилцуулж байх улирал бүр тасарч байна. Иймд холбогдох хэлтэс, агентлаг онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Тэргүүлэх чиглэл батлах тухай А/242 захирамжийн дагуу тэргүүлэх чиглэлийн жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан хагас бүтэн жилээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлж байхаар өгсөн үүргийн дагуу нэг ч сум тайлангаа ирүүлээгүй. Бодлогын хэлтсийн мэргэжилтэн хяналт тавьдаггүй байгаа тул цаашид тайлан мэдээг авч сумдын нэгдсэн дүнг гаргаж байх

Харьяа агентлагуудын төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай А/527 дугаар захирамжийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын харьяа агентлагуудын төрийн захиргааны албан хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийж, дүгнэж нэмэгдэл олгох үзүүлэлтийг боловсруулан батлах ажил удаашралтай байгаа тул аргачлалыг яаралтай боловсруулан батлуулах

Өгсөн зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 4 дүгээр улирлын захирамжийн хэрэгжилттэй хамт ирүүлэх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС